



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 07 сарын 04 өдөр

Дугаар А/474

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 78 дугаар зөвлөмжийн дагуу улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих Арвайхээр сумын халаалтын зуухнуудад шүүлтүүр тавих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 400.000.000 (дөрвөн зуун сая) төгрөгөөр Хангамж-Өргөө ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Шалгарсан гүйцэтгэгч аж ахуйн нэгж санхүүжилтээ авахад шаардагдах материалыг бүрдүүлэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100816